

Гарчиг

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Компанийн танилцуулга.....	4
1.2 Компанийн байгаль орчны бодлого	4
1.3 Нарийн сухайтын уурхайн танилцуулга	6
1.3.1 Байршил	6
1.3.2 Газрын засаг захиргааны харьяалал, дэд бүтэц эрчим хүч	6
1.4 Уурхайд ашиглагдах техник тоног төхөөрөмж.....	7
1.5 Ажиллах хүчний мэдээлэл	7
1.6 Уурхайн барилга байгууламж.....	8
1.6.1 Ажилчдын амрах байр.....	8
1.6.2 Засвар үйлчилгээний төв.....	9
1.6.3 Химийн лаборатори	10
1.6.4 Шатахуун түгээх станц (ШТС).....	11
1.6.5 Хогийн цэг.....	11
БҮЛЭГ 2. Нүүрс баяжуулах үйлдвэр.....	13
2.1 Баяжуулах үйлдвэр барилга байгууламж	13
2.2 Нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамж, ус зарцуулалт.....	13
2.3 Нүүрс баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамж.....	14
2.4 Баяжуулах үйлдвэрийн технологийн процесс.....	14
2.5 Баяжуулах үйлдвэрийн процесс	15
2.6 Баяжмал.....	15
2.7 Завсрын бүтээгдэхүүн.....	15
2.8 Хаягдал.....	16
2.9 Баяжмалаас хүнд орчныг салгах систем	16
2.10 Завсрын бүтээгдэхүүнээс хүнд орчныг салгах.....	16
2.11 Хаягдлаас хүнд орчныг салгах.....	16
2.12 Флотацийн систем болон нунтаг нүүрс авалт	17
2.13 Флотацийн баяжмал ба түүнийг усгүйжүүлэх схем	18
2.14 Флотацийн хаягдлыг усгүйжүүлэх схем.....	18
2.15 Эргэлтийн усны систем	18
2.16 Цэвэр усны хангамж	18
2.17 Өндөр шаламтай болон исэлдсэн нүүрс баяжуулах схем	18

2.18	Хуурай баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж.....	19
2.19	Хуурай баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамж.....	20
2.20	ХУУРАЙ АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИЙН СХЕМ	20
2.21	ZM-400 Хуурай баяжуулах үйлдвэр.....	21
2.21.1	Барилга байгууламж	21
2.21.2	Төхөөрөмжийн танилцуулга	21
2.21.3	ZM-400 хуурай баяжуулах үйлдвэр	21
2.21.4	Технологийн танилцуулга.....	21
2.21.5	Төхөөрөмжийн бүтэц.....	22
2.21.6	Хуурай баяжуулах үйлдвэрийн процесс.....	23
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....		
3.1	Гурвантэс сумын нийгэм эдийн засаг	24
3.2	Гурвантэс сумын газар ашиглалт	24
3.3	Гурвантэс сумын хүн ам.....	25
3.4	Гурвантэс сумын эдийн засаг	25
3.5	Гурвантэс сумын мал аж ахуй.....	25
3.6	Боловсрол.....	25
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ		
4.1	Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	26
4.2	Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл	26
4.3	Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл	27
4.4	Амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл	27
БҮЛЭГ 5. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....		
БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....		
6.1	Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд.....	29
6.2	Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	31
6.3	Усан орчинд хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд	32
6.4	Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ...	34
6.5	Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	35
БҮЛЭГ 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ		
БҮЛЭГ 8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ		

БҮЛЭГ 9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	38
БҮЛЭГ 10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
БҮЛЭГ 11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	40
БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	41
БҮЛЭГ 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	43
БҮЛЭГ 14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	45
БҮЛЭГ 15. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	46
БҮЛЭГ 16. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ	47

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал төсөл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

Цаашдаа улс эх орны хөгжил, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах, жилд 1 сая.тн цемент үйлдвэрлэх Хөх цавын цементийн үйлдвэр 2017 оны 6 сарын 9 нд ашиглалтад орж, 405 мян.м³ барилгын дүүргэгч материал үйлдвэрлэх Хийт бетоны үйлдвэрийг 2015 оны 5 дугаар сард ашиглалтад оруулсан мөн 14.6 сая.тн хүдэр боловсруулах Цагаан суваргын зэс-молибденийн баяжуулах үйлдвэрийн төслүүдийн бүтээн байгуулалтыг өрнүүлж байна.

Уул уурхайн нөхөн сэргээлт, болон аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагын чиглэлд орон нутаг болон, Монгол улсын хэмжээнд үнэлэгдсэн олон ажлыг амжилттай хэрэгжүүлж байгаа ба цаашид энэ чиглэлд тууштай анхааран ажиллах нь бидний зорилго юм.

1.2 КОМПАНИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсэж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах нь компанийн нийт ажиллагсдын нэн тэргүүний зорилт болно.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улсын байгаль орчны хууль, дүрэм, журам болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл билээ.


Баримтлах бодлого: “Монголын Алт” (МАК) компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаарх мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;
- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;

1.3 НАРИЙН СУХАЙТЫН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА

1.3.1 Байршил

Нарийн сухайтын нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт сумын төвөөс урагш 34 км, аймгийн төв Даланзадгад хотоос баруун тийш 296 км, Улаанбаатар хотоос баруун урагш 849 км, Шивээ хүрэн боомтоос хойш 56 км зайд оршино.



1.3.2 Газрын засаг захиргааны харьяалал, дэд бүтэц эрчим хүч

Гурвантэс сум нь манай орны хамгийн өмнөд захын сум бөгөөд хойд ба баруун талаараа Баянхонгор аймгийн Баянлиг, Баянговь, Шинэжинст сумуудтай, зүүн талаараа аймгийнхаа Сэврэй, Ноён сумуудтай, урд талаараа ӨМӨЗО-ны Эзнээ хошуутай тус тус хиллэнэ. Гурвантэс нь Монгол улсын хамгийн том газар нутагтай сум бөгөөд 2844 мян.га талбай нутаг дэвсгэртэй юм.

Нарийн Сухайтын ордын орчимд Монгол–Хятадын хилийн Шивээ хүрэн, Цүхгийн боомтууд байнгын ажиллагаатай ажиллаж байна. Нарийн сухайтын уурхайгаас Шивчхээгүйн боомт хүртэл 56 км хатуу хучилттай замтай. Хилийн боомтыг дайруулан БНХАУ–ас 70 км урттай 35кВ–ийн өндөр хүчдэлийн шугамтай. Овоотын хилийн цэргийн 0166-р анги, Гурвантэс сум руу цахилгаан дамжуулах шугам татсан, дэд станц барьсан цахилгаан эрчим хүчний байнгын эх үүсвэртэй.

1.4 УУРХАЙД АШИГЛАГДАХ ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Уурхайн хэмжээнд Орос, Герман, Япон зэрэг улсад үйлдвэрлэгдсэн өндөр үр бүтээлтэй техник, тоног төхөөрөмжийг сонгон ашигладаг. 2024 онд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийг дараах хүснэгтэн харуулав.

Хүснэгт 1. Уурхайд ашиглагдах техник, тоног төхөөрөмж

№	Техник, тоног төхөөрөмж	Хүчин чадал	Тоо хэмжээ /ш/
1.	Экскаватор ЭКГ – 10 УА	12.5 м ³	1
2.	Экскаватор RH 170	22м ³	7
3.	Экскаватор RH 120	15 м ³	2
4.	Экскаватор САТ 390	6 м ³	3
5.	Экскаватор САТ 390	6.5 м ³	1
6.	Экскаватор Hyundai LC 500	3 м ³	2
7.	Экскаватор Hyundai LC 520	3.2 м ³	1
8.	Atlas cop	229 мм	5
9.	Өрмийн машин Сандвик D75KS	250 мм	2
10.	Өрмийн машин Сандвик D45KS	229 мм	4
11.	Ачигч САТ 988Н	7-13 м ³	4
12.	Ачигч LW-1200	6,5 м ³	8
13.	Бульдозер САТ D10R	18,5 м ³	6
14.	Бульдозер САТ 834Н	8,3 м ³	2
15.	Бульдозер САТ 844Н	9	1
16.	Белаз 75306	220 тн	39
17.	Белаз 75131	130 тн	12
18.	Зам усалгааны Белаз 76473	32тн	4
19.	Автогрейдер САТ 16М	1,71м3	3
20.	Hitachi ex2600 Экскаватор	18 м3	1
21.	Ачигч lw-800	4.8 м3	3
22.	Экскаватор САТ 395	6.5 м3	6
23.	Экскаватор PC 1250-11R	7.1м3	3
24.	САТ 777 Автосамосвал	100 тн	11
25.	Хово Автосамосвал	70 тн	7
26.	Shacman f3000 авто чирэгч	80 тн	10
27.	Бусад үйлчилгээний машинууд		56

1.5 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ МЭДЭЭЛЭЛ

Нарийн сухайтын уурхай нь нийт 1,201 ажилтан ажиллагсадтай. Үүнээс инженер техникийн ажилтан 153 буюу нийт ажилтны 12,7%, Орон нутгийн ажилчин нийт 290 буюу 24,1%-ийг эзэлж байна. 2024 онд уурхайн ажиллах хүчний бүтэц орон тоо нэмэгдэж 1850 болсон бөгөөд өмнөх оны орон тоог 535-аар нэмэгдүүлсэн.

1.6 УУРХАЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

1.6.1 Ажилчдын амрах байр

Уурхайн ажилчдын ажиллаж амрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах барилга байгууламжуудыг өөрийн хүчээр барьж байгуулан ашиглаж байна. Үүнд:

- Ажилчдын хотхон - Эмнэлгийн анхан шатны тусламжийн цэг, инженер техникийн ажилтнуудын болон ажилчдын байр-3, спорт заал, хувцас угаалгын газар, зочид буудал, цэвэр усны нөөцийн савны байгууламж, хоногт 200-250 хүний бохирыг 95% хүртэл цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж зэрэг барилга байгууламж
- Туслах аж ахуйн хотхон
 - 64 хүний багтаамжтай ажилчдын байр;
 - Орон нутгийн иргэд гэр бүлээрээ ажиллаж амьдрах 8 айлын орон сууц;
 - 186.24м² хэмжээтэй гахайн байр;
 - 45.75м² хэмжээтэй тахианы байр;
 - Цэвэр усны нөөцийн савны байгууламж;
 - 126 м² хэмжээтэй ногооны зоорь;
 - 400 м² хүлэмж;
 - 70 хүний бохирыг 95% хүртэл цэвэршүүлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж зэрэг барилга байгууламж.



Аж ахуйн хотхон 64 ажилчдын байр



8 айлын орон сууц



Гахай тахианы байр



Нарийн ногооны хүлэмж

1.6.2 Засвар үйлчилгээний төв

Уурхайн захиргаа, нүүрс химийн лаборатори, гал тогоо, техник тоног төхөөрөмжийг угаах машин угаалгын байр, хаягдал тосны агуулах, засварын гарааж (бага оврын машины, 130 тонны белазын, 220 тонны белазын) уурын зуух, гагнуурын байр, машин угаалгын байрнаас гарсан усыг цэвэршүүлэх цэвэрлэх байгууламж, шатахууны агуулах зэрэг барилга байгууламж.



Уурхайн захиргаа



Засвар үйлчилгээний төв



Уурхайн амралтын хотхон



Спорт заал



Уурхайн эмнэлгийн байр



Гаалийн хяналтын талбай

1.6.3 Химийн лаборатори

Нарийн сухайтын үйл ажиллагаа баяжуулах үйлдвэр болон нүүрсний чанар тодорхойлох лабораторид дараах 7 химийн бодисыг ХАЛМ-ын дагуу ашиглаж байна.

Хүснэгт 2. НС-ын үйл ажиллагаанд ашиглаж буй химийн бодис

№	Бодисын нэр	ОУ-ийн нэршил	Химийн томьёо	CAS #
Үйлдвэрийн технологийн зориулалттай бодис				
1	Магнетид	Magnetite/ oxide	Fe ₂ O ₃	1309-38-2
2	Дизель түлш	Diesel fuel	C ₁₀ -C ₂₈ хүртэлх нүүрсустөрөгчдийн бүлэг агуулсан холимог	68334-30-5
3	Метилизобутил карбинол	Methyl Isobutyl Carbinol	C ₆ H ₁₃ OH	108-11-2
4	Флокулянт	Polyacryl amide	(C ₅ H ₅ NO) _N	9003-05-08
Лабораторийн зориулалттай бодис				
	Цууны хүчил	Acetic acid	CH ₃ COOH	64-19-7
	Калийн иод	Potassium iodide	KI	7681-11-0
	Калийн бром	Potassium bromide	KBr	7758—02-3



1.6.4 Шатахуун түгээх станц (ШТС)

Нарийн сухайтын уурхайн ШТС нь 100 тонны 10 ширхэг, 50 тонны 6 ширхэг түлшний агуулахтай бөгөөд нийт хүчин чадал нь одоогийн байдлаар 1300 тонн хүчин чадалтай. Нэмэлтээр 1000 тонн багтаамжтай түлшний агуулах барихаар стандартын дагуу төлөвлөж байна.

Баяжуулах үйлдвэрийн хувьд дизель түлшийг хэрэглэгдэх хэмжээгээр ойролцоох шатахууны агуулахаас түлшний машинаар тээвэрлэн үйлдвэрт байрлах 6 м^3 хэмжээтэй 2 ширхэг саванд юүлэх байдлаар хэрэглэх бөгөөд энэ нь богино хугацаанд хадгалагдана.



1.6.5 Хогийн цэг

Уурхайн үйл ажиллагаанаас гарсан ахуйн болон аюултай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан тусгайлан бэлдсэн хогийн цэгт ангилан ялгалт хийж байршуулж байна. Уурхайн үйл ажиллагаанаас гарах ахуйн болон аюултай, дахин боловсруулах хог хаягдлыг дахин боловсруулах, ачиж тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагад тогтмол нийлүүлдэг.

Ахуйн хог хаягдал /Шугшаа Уул ХХК-д тогтмол нийлүүлдэг/:

- Ахуйн хог хаягдал
- Хаягдал мод h
- Шил
- Хуванцар сав



Аюултай хог хаягдал /Аюултай хог хаягдал хүлээн авах эрх бүхий гэрээт компанид тогтмол нийлүүлдэг/

- Хаягдал тонны сав
- Агаар шүүгч
- Хаягдал поошиг
- Хаягдал дугуй
- Хаягдал тос
- Хаягдал төмөр
- Цахилгааны хаягдал



БҮЛЭГ 2. НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

2.1 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Үйлдвэрийн төслийг хүчин чадлын хувьд 2 үе шаттайгаар хэрэгжүүлж. Эхний ээлжид 1 сая тн/жилд нүүрс баяжуулах бага оврын (модулийн) үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Дараагийн шатанд 2 сая тн/ жилд хүчин чадалтай үйлдвэрийг барьж байгуулах юм.

Баяжуулах үйлдвэр нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Түүхий нүүрсний ил агуулах,
- Нүүрс хүлээн авах, бутлах хэсэг,
- Баяжуулах үйлдвэр (үндсэн тоног төхөөрөмж, удирдлагын өрөө)
- Нунтаг нүүрсний өтгөрүүлэгч, шүүлтүүр,
- Баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдлын талбай,
- Уурын зуух,
- Химийн бодисын агуулах.
- Оффис

2.2 НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН УСАН ХАНГАМЖ, УС ЗАРЦУУЛАЛТ

Үйлдвэр жилд бүрэн хүчин чадлаараа ажиллах үед процесст хамгийн ихдээ жилд $\approx 100,000$ м³ (4-5 л/сек) ус ашиглана. Дээрх хэмжээний усыг ил уурхайн шүүрлийн болон үерийн усаар 10-15 жил хангах бүрэн боломжтой. Уурхайн Уул-1 хэсгийн баруун хэсгээс 1.5 км зайнаас усыг 110 мм бүхий хоолойгоор татаж үйлдвэрийн хойно байрлах 3000 м³ багтаамжтай (7 хоногийн нөөц) ил усан санд усыг хуримтлуулж үйлдвэрт ашиглана.

Хүснэгт 3. Уурхайн үерийн усны хэмжээ

Их усны түвшний хэмжилт							
Огноо	Уулын 1-р хэсэг их ус						Нийт
	Баруун хэсэг		Зүүн хэсэг		Дунд хэсэг		
	Усны түвшин, м	Эзлэхүүн, м ³	Усны түвшин, м	Эзлэхүүн, м ³	Усны түвшин, м	Эзлэхүүн, м ³	
2018.08.18	1485.6	562228	1485.5	743889	1486.7	241666	1,547,783
2019.07.15	1485.7	584694	1488.1	1295561			1,880,255
2019.09.09	1485.938	602785	1488.454	1463584			2,066,369
2019.10.07	1485.875	595169	1488.076	1393695			1,996,480
2020.07.13	1486.096	622349	1488.628	1496173			2,118,522
2020.09.15	1485.836	590772	1488.381	1450020			2,040,792
2020.11.17	1485.527	553885	1488.527	1477213			2,031,098
2021.03.21	1486.39	659173.18	1488.763	1521462.44			2,180,635.6
2022.05.26	1486.750	705792	1488.971	1560756			2,266,548
2022.06.26	1486.586	684547	1488.828	1533954			2,218,501
2022.08.25	1486.223	637775	1488.672	1504347			2,142,122
2022.11.09	1486.243	640276	1488.584	1487854			2,128,130
2023.04.26	1489.459	668,050	1488.716	1,512,630			2,180,680
2023.07.04	1486.087	620,949	1488.632	1,496,844			2,117,793
2023.09.04	1485.598	562,301	1488.415	1,454,857			2,017,158
2023.09.26	1485.471	547,265	1488.27	1,425,194			1,972,459
2023.11.14	1485.30	527,510	1487.99	1,376,719			1,904,229



Жилийн 1 сая тонны хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэрт дараах хэмжээний усыг ашиглана. Үүнд:

- Үйлдвэрт шинээр нэмэх усны хэмжээ: 288 м³/өдөр (14-18 м³/цаг, 4-5 л/сек) 0.35 МПа
- 1 тонн түүхий нүүрс баяжуулахад < 0.1 м³/тн
- Үйлдвэр дотор нийт эргэлдэх усны хэмжээ: <600 м³
- 1 цаг үйлдвэрт шинээр нэмэх усны хэмжээ: 14-18м³/цаг
- 18 / 600=3% 1 цагт үйлдвэрээс алдагдах усны алдагдлын хувь .
- Үйлдвэрийн процессын усыг 97% -ийг эргүүлж ашиглана.

2.3 НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Сэхэ-Нарийн сухайтын 35 кВ-ын шугамаас салаалж 2500 кВА-35/0.4 кВ-ын дэд станц шинээр байгуулж үйлдвэрийг цахилгаанаар хангасан. Энэхүү дэд станц нь 35кВ-ын агаарын оруулгатай, 35/6 кВ-ын хүчдэлийн 1 х 2500 кВА чадалтай ачааллын дор автоматаар хүчдэл тохируулагчтай хүчний трансформатораар тоноглогдсон.

1 сая тн нүүрс баяжуулах модулийн дотор суурилуулах тоног төхөөрөмж: 82 ширхэг:

- Нийт тоног төхөөрөмжүүдийн суурилагдсан чадал: 1944 кВт,
- Үйлдвэр ажиллаж байх үед ашиглах бодит чадал 1172.49 кВт.


1 тонн нүүрс баяжуулахад 5.7-6.0 кВт*цаг/тн эрчим хүч шаардлагатай.

- Идэвхтэй чадал: 1174.99 кВт;
- Хуурмаг чадал: 1137.76 кВАр;
- Конденсаци явагдсаны дараах бүрэн чадал: 1292.20 кВа;
- Чадлын коэффициент: 0.92.

2.4 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕСС

- Нүүрс баяжуулах үйлдвэрийн орц дунджаар 25% хүртэлх үнслэгтэй 1 сая тонн тэжээлийн нүүрс байна.
- Жилд 170 тонн.цаг хүчин чадлаар 6000 цаг ажиллаж 73.16 хувийн гарц бүхий нийт 731.6 мян.тонн 5.37%-ийн үнслэгтэй баяжмал үйлдвэрлэн борлуулна. 3.57 хувийн гарцтай 35.7 мянган тонн завсрын бүтээгдэхүүн болон 23.27 хувийн гарц бүхий 232.7 мянган тонн хаягдлын зөвшөөрөл авсан овоолгын талбайд хадгална.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн схем



2.5 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ПРОЦЕСС

Ил уурхайгаас ирсэн түүхий нүүрсийг автосамосвал, эсвэл ачигчаар 140 тн-н багтаамжтай бункерт (101/1) өгнө. Бункерт том овор ихтэй чулуу, нүүрс орохоос сэргийлж 300 мм-ийн гулдмай шигшүүр бункер дээр байрлана. Материал бункерээс тэжээгч конвейер (101), туузан конвейероор (201) дамжин эргэлтэт бутлуурт (202) орох ба 0-50 мм-ийн хэмжээтэй бутлагдсан нүүрс тэжээгч (203), туузан конвейер (301) дамжин төв корпуст байрлах 3 бүтээгдэхүүн хүнд орчны гидроциклонд (302) тэвэрлэгдэн орно. Бутлуурын торны дээрх +50 мм-ийн материал өөрийн урсгалаар тусгай цоргоор гарах ба түүнийг ачигчаар зайлуулна. бүтээгдэхүүн гидроциклоны 1-р шатнаас баяжмал, 2-р шатнаас завсрын бүтээгдэхүүн, 3-р шатнаас хаягдал гарна.

2.6 БАЯЖМАЛ

3-н бүтээгдэхүүн гидроциклоны баяжмал нь (том баяжмал) 309, 310 –р чичиргээ шигшүүрүүдийн дээд бүтээгдэхүүнүүд болох бөгөөд тэдгээр нь центрифугээр (313) усгүйжүүлсний дараа баяжмалын конвейер (701) дээр унана. Баяжмалын хүнд орчин ялгах соронзон сепараторын соронзгүй бүтээгдэхүүн (шалам) болон флотацийн баяжмалыг (нунтаг баяжмал) усгүйжүүлсний дараа мөн 701–р конвейер дээр өгөх ба эдгээр нь нийлээд эцсийн баяжмал болох юм.

2.7 ЗАВСРЫН БҮТЭЭГДЭХҮҮН

3-н бүтээгдэхүүн гидроциклоны завсрын бүтээгдэхүүн нь өөрийн урсгалаар 307-р нуман шигшүүрт орох ба дээд бүтээгдэхүүн нь чичиргээ шигшүүрт (311) орж хүнд орчин болон шламаас сална. 311 –р чичиргээ шигшүүрийн дээд бүтээгдэхүүн, мөн шигшүүрийн 3-р хэсгийн доод бүтээгдэхүүн нь центрифугээр (314) усгүйжүүлсний дараа 702–р конвейер дээр тус тус унаж эцсийн бүтээгдэхүүн болно.

Завсрын бүтээгдэхүүнийг түүний чанараас хамаарч баяжмалд нийлүүлэх схемийг тусгаж өгсөн. Үүний тулд 302/2 хуваарилах хайрцгийг ашиглана.

2.8 ХАЯГДАЛ

3-н бүтээгдэхүүн гидроциклоны хаягдал нь завсрын бүтээгдэхүүнтэй адил өөрийн урсгалаар 312-р чичиргээ шигшүүрт орж улмаар шигшүүрийн дээд бүтээгдэхүүн нь хаягдлын конвейер (703) дээр унаж эцсийн бүтээгдэхүүн болно.

2.9 БАЯЖМАЛААС ХҮНД ОРЧНЫГ САЛГАХ СИСТЕМ

Баяжуулах процесст хүнд орчныг үүсгэхэд магнетидийг (Fe_3O_4) ашиглах ба магнетидын бүхэлдэг, соронзон чанарыг нь ашиглан дамжлагуудын урсгалуудаас салган буцаан процесст ашигладаг. Бүтээгдэхүүнүүдтэй алдагдаж буй бага хэмжээний магнетидыг шинээр нэмнэ.

3-н бүтээгдэхүүн гидроциклоны 0-50 мм-ийн хэмжээтэй баяжмал нь 400 мм-ийн диаметртай ган хоолой дамжин хуваарилах хайрцагт (302/1) орж хуваагдсаны дараа 1 мм-ийн нүхтэй нуман шигшүүрүүд (305, 306), чичиргээ шигшүүрүүдээр –D&R (309, 310) хүнд орчныг салгана. 309, 310 –р шигшүүрийн торны бүх хэсгүүдийн нүхний хэмжээ 0.5 мм байна. Өөрөөр хэлбэл нуман шигшүүрүүдийн (305, 306) доод бүтээгдэхүүн, мөн 309, 310-р шигшүүрүүдийн эхний хэсгээс гарсан доод бүтээгдэхүүнүүд нийлээд хүнд орчны зумпфэнд (324) өөрийн урсгалаар орж 325-р насосоор дамжин процесст эргэн орно.

Харин 309, 310-р шигшүүрүүдийн 2, 3-р хэсгээс гарсан доод бүтээгдэхүүнүүдийг баяжмалын шингэрсэн орчны зумпф (328), насосоор (329) баяжмалын соронзон сепараторт (315) шахна. Магнатыг агуулсан соронзон бүтээгдэхүүн нь буцаад өөрийн урсгалаар зумпфэнд (324) орж 325 -р насосоор дамжин систем эргэн орно.

Харин баяжуулж буй нүүрсний шинж чанараас хамаарч, ялангуяа шалам ихтэй болон исэлдсэн нүүрсийг баяжуулах тохиолдолд дээрх соронзтой бүтээгдэхүүнийг нунтаг нүүрсний хүнд орчны зумпфэнд (326) өгөх ба түүнийг 327-р насосоор 2 бүтээгдэхүүн хүнд орчны гидроциклонд шахна. Энэхүү схем шалам ихтэй болон исэлдсэн нүүрсийг баяжуулахад ашиглах ба цахилгаан шилжүүлэгчтэй хуваарилагч хайрцгийн (316) тусламжтайгаар схемийг шилжүүлнэ.

2.10 ЗАВСРЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ХҮНД ОРЧНЫГ САЛГАХ

Завсрын бүтээгдэхүүнээс хүнд орчныг салгах схем баяжмалынхтай их төстэй бөгөөд 3-н бүтээгдэхүүн гидроциклоны завсрын бүтээгдэхүүнээс хүнд орчныг салгахдаа 307 –р нуман шигшүүр ($a=1$ мм), 311-р чичиргээ (D&R) шигшүүрүүдийг тус тус хэрэглэнэ. Нуман шигшүүрийн (307) доод бүтээгдэхүүн, мөн 311 –р шигшүүрийн эхний хэсгийн доод бүтээгдэхүүн (хүнд орчин) нийлээд өөрийн урсгалаар хүнд орчны зумпфэнд (324) орж 325-р насосоор дамжин процесст эргэн орно. Харин уг шигшүүрийн 2-р хэсгийн доод бүтээгдэхүүн завсрын бүтээгдэхүүний шингэрсэн орчны зумпфэнд (330) өөрийн урсгалаар орох ба 331-р насосоор дамжин завсрын бүтээгдэхүүний соронзон сепараторт (317) орж магнетидийг нь ялгана. Уг соронзон сепараторын соронзон бүтээгдэхүүн өөрийн урсгалаар хүнд орчны зумпфэнд (324) орж 325-р насосоор дамжин процесст эргэн орно. 311- р чичиргээ шигшүүрийн эхний 2 хэсгийн торны нүхний хэмжээ – 0.5 мм байх ба харин 3-р хэсгийн торны нүхний хэмжээ 25 мм байна.

2.11 ХАЯГДЛААС ХҮНД ОРЧНЫГ САЛГАХ

3-н бүтээгдэхүүн гидроциклоны хаягдлаас хүнд орчныг (магнатад) салгах схем нь завсрын бүтээгдэхүүнийхтэй адилхан. 3-н бүтээгдэхүүн гидроциклоны хаягдал нь өөрийн урсгалаар 312 –р чичиргээ шигшүүрт (D&R) орох ба шигшүүрийн 1-р хэсгийн доод бүтээгдэхүүн нь (хүнд орчин) хүнд орчны зумпфэнд (324) орж 325-р насосоор дамжин процесст эргэн орно. Харин 312

–р шигшүүрийн 2 –р хэсгийн доод бүтээгдэхүүн нь хаягдлын шингэрсэн орчны зумпфэнд (332) өөрийн урсгалаар орох ба 333-р насосоор хаягдлын соронзон сепараторт (318) шахна.

2.12 ФЛОТАЦИЙН СИСТЕМ БОЛОН НУНТАГ НҮҮРС АВАЛТ

Баяжуулалтын үндсэн процессын нэг нь флотацийн дамжлага бөгөөд флотацар нүүрсний шламыг баяжуулна.

Үйлдвэрийн 3-н бүтээгдэхүүн гидроциклоны баяжмал болон завсрын бүтээгдэхүүний бүх шламгүйжүүлэх шигшүүрүүдийн (нуман болон D&R) доод бүтээгдэхүүнүүд (шалам <0.2 мм) 405 –р зумпфэнд цугларч 406 –р насосоор дамжин флотацийн тэжээл болно. Флотаци нь 4 камертай 1 шугамаас бүрдэх бөгөөд флотацийн баяжмал (нунтаг баяжмал), флотацийн хаягдал гарна.

Флотацийн процесст цуглуулагч урвалж (дизель түлш), хөөсрүүлэгч урвалжуудыг (МИБК - метилизобутилкарбинол) хэрэглэнэ.

Хүснэгт 4. Баяжуулах үйлдвэрт ашиглах химийн урвалж бодис, зарцуулалт

№	Урвалж бодис	Химийн нэгдэл	Зарцуулалт	
			Кг/тн	≈1 жил тн
1	Магнатыг	Fe ₃ O ₄	≤ 1	1000
2	Цуглуулагч	Дизель	≤ 1.2	364
3	Хөөсрүүлэгч	МИБК	≤ 0.2	61
4	Флокулянт	Полиакриламид	≤ 0.3	91

Магнатыг: Хүнд орчинд үүсгэх зорилгоор гидроциклонд магнайтыг нэмж өгнө. Хүнд орчинд баяжуулах технологид маш нарийн ширхэгтэй магнетитийг (Fe₃O₄) суспензи үүсгэгч болгон хэрэглэх ба дараах шинж чанартай: Физик шинж чанар: 98% нь 56 микроноос бага байх, 70 мтесла соронзонгийн агуулга >97%, Хатуугийн нягт > 4.9т/м.

Флотацийн урвалжууд: Флотацийн урвалжууд нь хэмжих болон дамжуулах насосын хамт урвалжийн хэсэгт хадгалагдана. Урвалж бэлдэх, нийлүүлэх хэсэг нь НБҮ-ийн үндсэн корпусын хажууд болон дотор тусдаа битүү, агааржуулалттай өрөөнд хадгална. Флотацийн аргаар баяжуулахад цуглуулагч болгож дизель түлш, хөөсрүүлэгч болгож МИБК ашиглана.

- **Дизелийн түлш:** Туйлгүй урвалж бөгөөд түүнийг цуглуулагч болгон хэрэглэнэ. Флотацийн процесст түүнийг цэврээр нь, эсвэл 1-10% усан эмульс байдлаар хэрэглэдэг.
- **Хөөсрүүлэгч МИБК (метилизобутилкарбамат):** Спиртийн бүлгийн доод молекулт бүтээгдэхүүн бөгөөд химийн томьёо нь: C₆H₁₃ОН.

Флокулянт полиакриламид (ПАА): Нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн усны зарцуулалт 2-5м³/т байдаг бөгөөд шинээр нэмэх цэвэр усны зарцуулалтыг багасгах зорилгоор шламын усыг цэвэрлэж эргүүлэн ашигладаг. Ингэснээр 1 тн нүүрсийг баяжуулахад зарцуулагдах шинээр нэмж авах цэвэр усны хэмжээ 0.1-0.2м³/т хүртэл багасах боломжтой. Нүүрсний шламыг тунаахад өргөн хэрэглэгддэг флокулянтуудын нэг бол полиакриламид (ПАА) бөгөөд энэ нь өндөр молекулт нэгдэл юм. Хуурай ПАА нь шаргал өнгөтэй, полимерийн агуулга 52-66%, аммонийн сульфатын агуулга 15-20% байдаг. Хуурай бодисыг олон давхар цаасан уут эсвэл полиэтилен уутанд 25кг жинтэйгээр савлаж нийлүүлдэг.

2.13 ФЛОТАЦИЙН БАЯЖМАЛ БА ТҮҮНИЙГ УСГҮЙЖҮҮЛЭХ СХЕМ

Флотомашин (408) хөөсөн бүтээгдэхүүн нь өөрийн урсгалаар 409-р зумпфэнд орох ба 410 –р насосоор баяжмалын пресс-филтерт (411) шахагдана. Пресс-филтерийн шүүгдсэн материалыг нь 412-р конвейерын тусламжтайгаар 701–р конвейер өгөх ба том баяжмалтай нийлэн эцсийн баяжмал болно.

2.14 ФЛОТАЦИЙН ХАЯГДЛЫГ УСГҮЙЖҮҮЛЭХ СХЕМ

Флотацийн хаягдал шлагмыг усгүйжүүлэх асуудал үйлдвэрийн чухал хэсэг бөгөөд үйлдвэрийг эргэлтийн усаар хангах гол хэсэг.

Флотомашин (408) камерын бүтээгдэхүүн буюу хаягдал нь өөрийн урсгалаар 601 , 602 – р өтгөрүүлэгчид орж өтгөрсөн материалыг нь 603 –р насосоор хаягдлын пресс-филтерт (612) шахна. Пресс-филтерт шүүгдсэн материал нь нунтаг хаягдал болох ба 612 –р конвейерээр гадагшилна.

2.15 ЭРГЭЛТИЙН УСНЫ СИСТЕМ

Баяжуулах үйлдвэрийн баяжмалын пресс-филт (411) болон хаягдлын пресс-филтрийн (612) шүүгдэх, хаягдлын өтгөрүүлэгчийн (601, 602) халианууд нийлээд эргэлтийн усыг бүрдүүлэх бөгөөд эргэлтийн усны бак (605) болон насосоор (606) дамжин процессын хэрэгцээт газруудад түгээгдэнэ.

2.16 ЦЭВЭР УСНЫ ХАНГАМЖ

Баяжуулалтын бүтээгдэхүүнүүдтэй хам чийгшил байдлаар алдагдаж буй уснууд, мөн механикаар хаягдаж буй усыг гаднаас ирж буй цэвэр усаар сэлбэнэ. Цэвэр ус хангамжийн схемийг дараах зурагт үзүүлэв.

2.17 ӨНДӨР ШАЛАМТАЙ БОЛОН ИСЭЛДСЭН НҮҮРС БАЯЖУУЛАХ СХЕМ

Баяжуулах үйлдвэрт хэт өндөр анхдагч шаламтай, исэлдсэн нүүрс орох тохиолдолд флотаци болон эргэлтийн усны системд ачаалал үүсэхээс гадна исэлдсэн нүүрсийг флотациар баяжуулах боломжгүй байдаг билээ. Ийм учраас шалам ихтэй, исэлдсэн нүүрс орж ирэх тохиолдолд технологийн схем болон өөр горимд шилжин ажиллана. Үүний тулд:

- Флотацийн шугамыг бүрэн зогсооно (өөрөөр хэлбэл флотацийн тэжээлийг бүрэн хааж, тэжээлийг нь 601, 602 –р өтгөрүүлэгч рүү шилжүүлнэ)
- Флотацийн пресс-филтер хаягдал шаламд шилжин ажиллана.
- Шлагмыг баяжуулах гол цикл нь 2 бүтээгдэхүүн хүнд орчны гидроциклон болно.

Хүснэгт 5. Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж	Загвар болон Тодорхойлолт	Тооцоолсон хүчин чадал,	Техникийн хүчин чадал	Тоо хэмжээ
1	Эргэлтэд бутлуур	МХС-3350	200 т/ц	230 т/ц	1
2	Түүхий нүүрс баяжуулах хүнд орчны циклон	S-3GHMC200/80	187 т/ц	200 т/ц	1
3	Баяжмал усгүйжүүлэх нуман шигшүүр	242060, $\delta=1\text{мм}$	365 м ³ /ц	273 м ³ /ц	2
4	Завсрын бүтээгдэхүүн усгүйжүүлэх нуман шигшүүр	242060, $\delta=1\text{мм}$	219 м ³ /ц	273 м ³ /ц	1

№	Тоног төхөөрөмж	Загвар болон Тодорхойлолт	Тооцоолсон хүчин чадал,	Техникийн хүчин чадал	Тоо хэмжээ
5	Баяжмал усгүйжүүлэх шүүлтүүр	Банана шигшүүр 2.4 х 4.8м	118 т/ц	89 т/ц	2
6	Завсрын бүтээгдэхүүн усгүйжүүлэх шигшүүр	Банана шигшүүр 2.4 х 4.8м	60 т/ц	129 т/ц	1
7	Нунтаг хаягдал усгүйжүүлэх шигшүүр	Банана шигшүүр 2.4 х 4.8м	80 т/ц	176 т/ц	1
8	Нунтаг баяжмалын нуман шигшүүр	242060, $\delta=0.2\text{мм}$	322 м ³ /ц	175 м ³ /ц	2
9	Нунтаг завсрын бүтээгдэхүүний нуман шигшүүр	152060, $\delta=0.4\text{мм}$	75 м ³ /ц	110 м ³ /ц	1
10	Нунтаг хаягдлын нуман шигшүүр	152060, $\delta=0.4\text{мм}$	49 м ³ /ц	110 м ³ /ц	1
11	Баяжмалын соронзон сепаратор	HMDAФ1219×2972	247 м ³ /ц	300 м ³ /ц	1
12	Завсрын бүтээгдэхүүний соронзон сепаратор	HMDAФ914×1524	75 м ³ /ц	90 м ³ /ц	1
13	Нунтаг хаягдлын соронзон сепаратор	HMDAФ914×1524	49 м ³ /ц	90 м ³ /ц	1
14	Баяжмалын центрифуг	HSG1100	118 т/ц	140 т/ц	1
15	Завсрын бүтээгдэхүүний центрифуг	HSG750	35 т/ц	70 т/ц	1
16	Флотацийн камер	XJM16-4	325 м ³ /ц	448 м ³ /ц	1
17	Нунтаг нүүрсний центрифуг	H900	27 т/ц	50 т/ц	1
18	Баяжмалын даралтад шүүлтүүр	KXGZ400/1600-X/U	23 т/ц	24 т/ц	1
19	Өндөр хурдтай өтгөрүүлэгч	SIPT7	374 м ³ /ц	308 м ³ /ц	2
20	Хаягдал шламгүйжүүлэх даралтад шүүлтүүр	KXGZ400/1600-X/U	17 т/ц	24 т/ц	1

2.18 ХУУРАЙ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Нүүрс хуурай аргаар баяжуулах FGX-12 болон FGX-24A хуурай баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулснаар жилд 2 сая.тн нүүрс хуурай аргаар баяжуулах боломж бүрдсэн.

Хуурай баяжуулах үйлдвэр дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Түүхий нүүрсний талбай
- Түүхий нүүрс хүлээн авах бункер
- Бутлан ангилах хэсэг. / Бутлуур, Шигшүүр/
- Баяжуулах хэсэг / баяжуулах ширээ, удирдлагын өрөө гэх мэт /
- Баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдлын талбай

2.19 ХУУРАЙ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

FGX12 хуурай аргаар нүүрс баяжуулах үйлдвэрийг Сэхэ-Нарийн сухайтын 35 кВ – ийн ЦДАШ-аас салаалж авсан 2500кВА чадал бүхий 35/6 кВ – ийн дэд станцын 3-р гаргалгын шүүгээнээс хангаж, FGX12 үйлдвэрийн хажууд **630кВА** чадал бүхий 6/0.4 кВ – ийн КТПН-ээс тэжээдэг.

FGX24A хуурай аргаар нүүрс баяжуулах үйлдвэрийг Сэхэ-Нарийн сухайтын 35 кВ – ийн ЦДАШ – ийн төгсгөл 6300кВА чадал бүхий 35/6 кВ – ийн дэд станцын 2-р гаргалгын шүүгээнээс хангаж, FGX24A үйлдвэрийн хажууд **1000кВА** чадал бүхий 6/0.4 кВ – ийн КТПН-ээс тэжээдэг.

FGX12 болон FGX24A үйлдвэрүүд нь 0.4 кВ – ийн хүчдэлийн түвшинд ажиллах цахилгаан хөдөлгүүрүүдтэй ба цахилгааны ачааллыг нийт цахилгаан хөдөлгүүрийн тоо, нийт суурилагдсан чадалд тулгуурлан тооцоолсон болно.


- Нийт цахилгаан хөдөлгүүр: **50ш**
/ FGX12 – 15 ширхэг, FGX24A – 35 ширхэг /
- Нийт цахилгаан хөдөлгүүрүүдийн суурилагдсан чадал: **1329.75 кВт**
/ FGX12 – 443.25кВт, FGX24A – 886.75кВт /

Хуурай аргаар нүүрс баяжуулах үйлдвэр нь жилд 2 сая тонн, цагт 330 тонны хүчин чадалтай бөгөөд 1 тонн нүүрс хуурай аргаар баяжуулахад **4 кВт*цаг/тн** эрчим хүч зарцуулна.

2.20 ХУУРАЙ АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИЙН СХЕМ

Үйлдвэр жилд 2 сая тонн цагт 330 тонн, хүлээн авч 6000 цаг ажиллана. Хуурай баяжуулах үйлдвэр нь 7 хоногийн 6 хоногт нь 10 цагаар 2 ээлжээр тасралтгүй ажиллах бөгөөд 1 хоногт сул зогсон урсгал засвар үйлчилгээ хийхээр төлөвлөсөн.

Хуурай баяжуулах үйлдвэрийн технологийн схем



Хүснэгт 6. Материалын баланс

Бүтээгдэхүүн	Гарц, %	Гарц, тн	Үнслэг (%)	Чийг (%)	Илчлэг (ккал/кг)
Баяжмал	73,6	243	16,1	4,1	6301
Завсар	9,7	32	36,9	3,8	4572
Хаягдал	16,7	55	81,6	2,3	
Тэжээл	100	330	29,1	3,8	5081

2.21 ZM-400 Хуурай баяжуулах үйлдвэр

2.21.1 Барилга байгууламж

Нүүрсийг хуурай аргаар баяжуулах ZM-400 маркын үйлдвэр нь жилд 2 сая.тн нүүрсийг боловсруулах хүчин чадалтай.

Тус үйлдвэр нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Тэжээлийн нүүрс хүлээн авах бункер
- Бутлах шигших хэсэг /шигшүүр болон бутлуур/
- Үндсэн баяжуулах хэсэг /баяжуулах ширээ, тоос сорох систем/
- Баяжмалыг ангилах шигшүүр
- Баяжмал хадгалах сило /1000 болон 2000 тоннын багтаамжтай/, ачилтын конвейер

2.21.2 Төхөөрөмжийн танилцуулга

ZM-400 үйлдвэрийн технологийн гол зарчим нь нүүрс, чулууны нягтын зөрүүг ашиглаж агаарын тусламжтайгаар ялгах нягтын орчинг үүсгэн баяжуулдаг. Тодорхой бүхэллэгтэй материалыг агаараар үлээлгэхэд доод хэсэгт нь хүнд, дээд хэсэгт нь хөнгөн нягттай хэсгүүд ялгардаг бөгөөд сэгсрэх ширээний тусламжтайгаар баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдал гэсэн 3 бүтээгдэхүүн болж үйлдвэрээс гарна.

2.21.3 ZM-400 хуурай баяжуулах үйлдвэр



2.21.4 Технологийн танилцуулга


Хуурай баяжуулах үйлдвэр нь технологийн дараах онцлогуудтай:

1. Нэг тонн нүүрсэнд ногдох хөрөнгө оруулалтын зардал нь бусад нүүрс ялгах аргуудаас харьцангуй бага, угсарч суурилуулах хугацаа богино, ашиглалтын зардал бага.

2. Ус ашиглахгүй хуурай аргаар баяжуулдаг учраас нүүрсний шаварлаг усыг цэвэрлэх систем байхгүй, нүүрсний лагийн бохирдол байхгүй. Хүчин чадал өндөр, ялангуяа эрчим хүчний нүүрсний хувьд баяжуулалтын дараа нүүрсний чийг нэмэгдэхгүйгээс гадна баяжуулалтын үед агаарын нөлөөгөөр түүхий нүүрсний гаднах чийг зохих түвшинд багасдаг.

3. Технологийн хувьд энгийн, автоматжуулалт сайтай.

Тоног төхөөрөмж холболтын схем



Хүснэгт 7. Техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	ZM-400
1	Тэжээлийн нүүрсний бүхэллэгийн хэмжээ	мм	<u>100 ~ 0</u>
2	Тэжээлийн нүүрсний гадаад чийг	%	<u><10</u>
3	Хүчин чадал	цаг/тн	<u>350 ~ 400</u>
5	Суурилагдсан хүчин чадал	кВт	<u>1250</u>
6	Овор хэмжээ	урт	<u>25000</u>
		өргөн	<u>17300</u>
		өндөр	<u>10500</u>

2.21.5 Төхөөрөмжийн бүтэц

Уг систем нь дараах 5 хэсгээс тогтоно:

1. Тэжээлийн нүүрс бэлдэх хэсэг нь тэжээл хүлээн авах бункер, тэжээгч, анхдагч нүүрсний конвейер, шигшүүр, булт бутлуураас бүрдэх ба хуурай ялгах сепараторыг тэжээлээр жигд хангах үүрэгтэй. Бутлуур, шигшүүр нь баяжуулах үндсэн ширээнд 80мм-ээс ихгүй бүхэллэгтэй тэжээлийг өгөх үүрэгтэй.


2. Үндсэн баяжуулах ширээ: тэжээлийн нүүрснээс чулууг ялгах үүрэгтэй үндсэн тоног төхөөрөмж

3. Агаар өгөх болон тоос барих хэсэг: Үндсэн баяжуулах ширээний доороос агаар өгөх, нүүрс баяжуулах үед үүссэн тоосыг цамцат фильтр ашиглан шүүх үүрэгтэй.

4. Бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах хэсэг: баяжмалыг 2000м³ болон 1000м³ багтаамжтай силосонд хадгалж силосноос нүүрс тээврийн машинд шууд ачилт хийх үүрэгтэй.

5. Удирдлагын өрөө автоматжуулалтын хэсэг.

Зураг 1. Тоног төхөөрөмжийн холболтын зураг



1 – нүүрс хүлээн авах бункер, 2 – нүүрс өгөх систем, 3 – үндсэн сепаратор, 4 – туузан конвейер, 5 – баяжмалын туузан конвейер, 6 – ерөнхий вентилятор, 7- тоос хураах уутнаас тоос зайлуулах импульсийн систем, 8 - тоос сорох вентилятор.

Хүснэгт 8. Техникийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Утга
Тэжээлийн бүхэллэг		мм	0-80
Хүчин чадал		т/цаг	90-110
Ашигт үйлийн коэф		%	>97
Тэжээлийн нүүрсний чийглэг		%	≤8
Хамгийн бага бүхэллэгийн хэмжээ		мм	2
Нийт хүчин чадал		кВт	310
Төхөөрөмжийн хэмжээ	Урт	м	14
	Өргөн	м	4.2
	Өндөр	м	3.5
Эзлэх талбай		м ²	59

2.21.6 Хуурай баяжуулах үйлдвэрийн процесс

Нүүрс хүлээн авах, бутлан ангилах хэсэг: Уурхайгаас нүүрсийг белаз болон ховоогоор түүхий нүүрсний талбайд буулгана. Түүхий нүүрсний талбайгаас LW1200 болон САТ988 ачигчаар нүүрс хүлээн авах бункерт өгнө. Бункерийн дээр 300 мм-ийн гулдмай шигшүүр байрлана. 0-300 мм бүхэлтэйгээ нүүрс бункерээс тэжээгүүр болон туузан конвейроор дамжин 80 мм-ийн шигшүүрээр орно. Шигшүүрийн дээд анги /+80 мм/ булт бутлуураар орох ба шигшүүрийн доод анги туузан конвейроор дамжин үндсэн төхөөрөмж рүү орно.

Хуурай баяжуулалт : Баяжуулах ширээ

-80 мм хүртэл буталсан нүүрс үндсэн төхөөрөмж болох баяжуулах ширээгээр орох ба баяжуулах ширээн дээр буцах, давших хөдөлгөөн болон ширээний доороос өгөх агаарын нөлөөнд хүндийн хүчний ялгаан дээр тулгуурлаж баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдал 3 бүтээгдэхүүн туузан конвейроор дамжин баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдлын талбайд хуримтлагдана.

Хүснэгт 9. Үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмж	Тоо хэмжээ
1	Тэжээгч	1
2	Бутлуур	1
3	Шигшүүр	1
4	Баяжуулах ширээ	3

5	Тоос баригч систем	3
---	--------------------	---

Хүснэгт 10. Туслах тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмж	Тодорхойлолт	Тоо хэмжээ
1	Агаар өгөлтийн систем		3
2	FGX-24А Баяжмалын конвейер	1000 мм	1
3	FGX-12 Баяжмалын конвейер	800 мм	1
3	FGX-24А Хаягдлын конвейер	800 мм	1
4	FGX-24А Завсрын.Бүт конвейер	800 мм	1
5	FGX-12 Завсрын.Бүт конвейер	650 мм	1
6	FGX-12 Хаягдлын конвейер	650 мм	1
7	Түүхий нүүрсний конвейер	1000 мм	1
8	FGX-12-ийн тэжээлийн конвейер	1000 мм	1
9	FGX-24А-ийн тэжээлийн конвейер	1000 мм	1

**БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-
ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

3.1 Гурвантэс сумын нийгэм эдийн засаг

Гурвантэс сум нь 1954 онд анх Тост нэртэйгээр Сэврэй сумын 1-р баг, Ноён сумын 3, 4, 5 дугаар багууд нийлж Улаан толгой гэдэг газар 281 өрх, 943 хүн амтай 63.2 мянган малтайгаар байгуулагджээ. 1960 онд БНМАУ-ын ардын их хурлын тэргүүлэгчдийн зарлигаар Гурвантэс сум гэж нэрлэгдэн, одоогийн байрлаж байгаа уртын дэнж гэх газар төвлөрсөн байна. Одоогийн байдлаар нутаг дэвсгэрийн хэмжээ 27.9 мян.кв.км байна. Хойд баруун урд талаараа Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баянговь, Баянлиг, Зүүн, Зүүн хойд талаараа өөрийн аймгийн Сэврэй, Ноён, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны эзний хошуутай хиллэж Говь алтайн нурууны цөлөрхөг бүсэд оршдог. Аймгийн төвөөс 320 км, Улаанбаатар хотоос 870 км алслагдан оршдог байна.

Тус сумын нутаг дэвсгэр нь Говь-Алтайн нурууны цаад цөлөрхөг бүсэд багтана. Гурвантэс сумын нутагт Нэмэгт, Гилбэнт, Суварга, Эрдэнэ зэрэг өндөр сүрлэг уулс, Тэгшийн гурван гол, Арван гурван даац, Бүг, Сайрдаг, Гурил, Хулангийн хөндий Шаригийн ганга зэрэг олон арван км үргэлжилсэн хөндий хоолойнуудтай, Зуун мод, Зулганай, хэрмэн цав, Наран, Наран даац, Хайлааст зэрэг горхи ус, баян бүрдүүд зэрэг хэдийд ч болов сэтгэлийг татсан байгалийн үзэсгэлэнт газруудтай. Торомхон, Нэмэгтийн баруун зүүн горхи, Салхит дуслуур, Улаан хад, Баганат зэрэг нүд ходоод, гэдэсний болон хүний бие мах бодийн эмгэгийг эмчилдэг рашаан устайгаас гадна, Хармаг, Тэмээн хөх, Жигд, Алтангагнуур, Лидэр, Хонин ба морин шарилж, Хар шаваг, улаан ба цагаан гоёо, Чихэр өвс, Нохойн хошуу, Таван салаа, Хар өвс, Зэрлэг сонгино, шувуун хөл, гоньд, Хөмүүл, таана зэрэг эмийн болон хүний хоол хүнсэнд амтлагчаар буюу энгийн байдлаар хэрэглэгддэг сайн чанарын ургамлууд ихээр ургадаг.

Засаг захиргааны анхан шатны нэгж болох Гоёот /нэгдүгээр баг/, Баясах /хоёрдугаар баг/ Тост /гуравдугаар баг/ Урт /дөрөвдүгээр баг/, Бага овоо /тавдугаар баг/ гэсэн 5 багтай.

3.2 Гурвантэс сумын газар ашиглалт

Гурвантэс сум нь 2,796,727.0 га газар нутагтай бөгөөд үүнээс хөдөө аж ахуйн эдэлбэр газар 1,439,740.4 га, ойн сан бүхий газар 233738.0га, улсын тусгай хэрэгцээний газар 1,121,510.3 га-г эзэлнэ. Сумын газар нутгийн ихэнх хувийг малын бэлчээр ба тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдэг.

Сумын ард иргэдийн дунд газар өмчлөлийн талаар судалгаа явуулахад газар өмчилж авсан иргэд 69.8%, аваагүй иргэд 30.2%, үүнээс сумын төвд газар өмчилж авсан иргэд 98.6%, аймгийн төвд газар өмчилж авсан нь 1.4% байна. Харин газар эзэмшдэг эсэх талаар судалгаа явуулахад 56.2% нь тийм, 43.8% нь үгүй гэж хариулжээ.

Сумын иргэдээс өвөлжөө хаваржааны доорх газраа албан ёсны гэрээгээр эзэмшиж байгаа байдлыг судлахад эзэмшлийн гэрчилгээтэй нь 76.8%, эзэмшлийн гэрчилгээгүй нь 23.2% байна.

3.3 Гурвантэс сумын хүн ам

Аймгийн хэмжээнд 2016 оны эцсээр 4,729 хүн тоологдсон нь өмнөх оноос 209 хүнээр буюу 5.1 хувиар өсжээ. Гурвантэс сумын 2016 оны байдлаар хүн амын тоонд багийн эзлэх хувийг доор үзүүлэв. Тус суманд халхчууд голлон амьдардаг. Цөөн тооны буриад, дөрвөд ястан сургууль, ажил болон бусад шаардлагаар суманд гэр бүлийн хамт ирж суурьшиж байна.

3.4 Гурвантэс сумын эдийн засаг

Өрхийн орлого: Гурвантэс сумын эдийн засгийн голлох салбар нь Мал аж ахуй, уул уурхай юм. Сумын төвд төсөвт 6 байгуулга, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3 үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна холбооны салбар, банкны 4, цаг уур, шуудан холбоо, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХХК, болон Шатахуун түгээх станцууд зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд ажиллаж байна. Сумаас 55 км-т орших Дунд голын давсны уурхайгаас “Говь гурван сайхан” “Асралт” Сонгодог нөхөрлөл нь жилдээ 220 орчим тонн давс олборлож борлуулдаг байна. Мөн сумын төвөөс 25 км-т орших “Хүрэн толгой коал майнинг”, “МАК” ХХК-ний Нарийн сухайтын уурхай, “Саус гоби сэндс” ХХК, “Өсөх зоос” ХХК, Жавхлант орд зэрэг ХХК-д нүүрс олборлон БНХАУ-д экспортолж байгаа бөгөөд Алтны АГМ майнинг ХХК, хайрганы Чухам жаргалан ХХК, чулууны Баатарван транс ХХК, өмнийн говийн баялаг зэрэг ХХК-д үйл ажиллагаа явуулдаг.

Сумын цэцэрлэгийн 3 байранд жилдээ 300 гаруй хүүхэд хүүхэд хүмүүжиж, 15 ортой хүн эмнэлэг, 250 суудалтай соёлын төв, номын сан болон 16 хүний бүрэлдэхүүнтэй цагдаагийн тасаг ажиллаж байна. 2005-2006 оны хичээлийн жилээс 8 жилийн дунд сургууль 11 жилийн сургалттай сургууль болон өргөжсөн бөгөөд өдгөө хичээлийн хоёр байранд мянга гаруй хүүхэд суралцаж байна.

3.5 Гурвантэс сумын мал аж ахуй

Гурвантэс сум бэлчээрийн мал аж ахуй амьжиргааны эх үүсвэр нь хэвээр байна. Бэлчээрийн мал аж ахуйн судалгаанаас авч үзэхэд тэмээ, ямааны аж ахуй өсгөх нэн зохистой бүсэд хамрагдаж байгаа боловч сүүлийн жилүүдийн байгаль-экологи, уур амьсгалын өөрчлөлттэй уялдан бэлчээрийн ургамлын гарцад өөрчлөлт орохын зэрэгцээ зарим нэг унаган ургамлуудын төрөл зүйл ч алга болжээ. Эдгээр хүчин зүйлүүдийг тогтоох шалгуур үзүүлэлтэд малын тоо толгой зүй ёсоор багтдаг. Сумын малын тоо 2023 оны жилийн эцсийн малын тооллогоор нийт 136,570 толгой мал буюу тэмээ 7,983, адуу 3,048, үхэр 530, хонь 9,338, ямаа 115,648 тус тус тоологдсон байна. 2022 оны жилийн эцсийн малын тоотой харьцуулахад нийт 37,033 толгой мал буюу 21,3 хувиар буурсан байна. Малын төрөл тус бүрээр задалбал тэмээ 582 буюу 6,7 хувиар, адуу 271 буюу 8,1 хувиар, үхэр 56 буюу 9,5 хувиар, хонь 1,950 буюу 17,2 хувиар, ямаа 34,197 буюу 22,8 хувиар тус тус буурчээ.

3.6 БОЛОВСРОЛ

Сумын хэмжээнд 11 жилийн тогтолцоотой 160, 320 хүүхдийн суудалтай хичээлийн 2 байртай 1 сургууль байгаа бөгөөд 1000 гаруй сурагчтай үүний 150 хүүхэд нь дотуур байранд амьдарч байна. Сургуулийн хэмжээнд нийт багш 50, ажилчид 35 байна.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

4.1 АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тоосжилт, хорт хий, утаа, нүүрсний тоосонцор байж болох юм. Уурхайн байрлаж буй хэсэг нь хуурай уур амьсгалтай, салхи шуурга ихтэй, говь цөлийн бүс бөгөөд ургамлын бүрхэвч тачир сийрэг, нимгэн давхаргатай хөрс тул тоосжилт ихээр үүсэх боломжтой юм.

Нөлөөллийн шинж чанар, эх үүсвэр, хэмжээ, эрчим нь: Хөрс хуулалт, хөрсний догол, мөргөцөг гаргах, мөн олборлолт хийх зэрэг ажлууд хийх явцад агаарт үүсэх их хэмжээний тоос, салхи, шуургаар дамжин тархалт ихсэн. Говийн нөхцөлд салхины хурдны давтагдал их байдаг нь ордын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын хөрснөөс суларсан шороо хийсэж агаар бохирдуулах нь их байж болзошгүй юм.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Уулын ажлын үед болон нүүрс тээвэрлэлтийн үед уурхайн орчимд их хэмжээний тоос, тоосонцор үүсэх бөгөөд энэ нь агаар орчинд төдийгүй уурхайн орчмын зэрлэг амьтан, мал, ургамлын бүлгэмдэл, уурхайн ажилчид болон уурхайн ойр амьдрах хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Үргэлжлэх хугацаа: Агаар мандлын бохирдол нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд маш түргэн үгүй бол маш удаан, эсвэл хүний бие махбодын тогтолцоог аажмаар удаан гэмтээх зэрэг янз бүрээр нөлөөлнө.

4.2 ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хөрсөн дэх органик бодисын агууламж нь 1.0%-аас бага, сул шүлтлэг, шүлтлэг чанар нь кальци, магнийн катионуудын концентрациас хамаарч хөрсний давхарга бүрд харилцан адилгүй байна. Цөлийн бор хөрс бүрэлдэх явц нь бусад төрлийн хөрснүүдээс ялгаатай байдаг. Учир нь говийн хуурай цаг уур болон ховор тохиолдох хур тунадас зэргээс шалтгаалж, хөрсний 80% нь эрдэсэжсэн байдаг. Хөрсний шинж чанар нь натрийн карбонат, бусад хэлбэрийн карбонат, ууссан давс, шохойлогтой эсэхээс хамаарч тодорхойлогдоно. Судлаачид говийн хөрс тогтворжиход хөрсний чийгийн горим их нөлөө үзүүлсэн гэж үздэг. Түүний нөлөөгөөр хөрсний өнгөн хэсэг дээр карбонат, бикарбонат хуримтлагдаж, давс агуулсан нимгэн шаварлаг үе бий болдог. Цөлийн хөрс нь өвлийн цагт өнгөн хэсэгтээ 1-1.5 м гүнд хүртэл хөлдөнө. Улирлаас хамааран жилд 6-7 дугаар сарын турш урт удаан хугацаанд хөлдөнө. Дулааны улиралд бороо чийг ихтэй үед хөрсөн дэх биологийн идэвх ихээхэн дээшилдэг.

Давсны өндөр агууламж, органик бодисын бага агууламж, хөрсний шүлтлэг чанар нь хөрсийг салхи, усны элэгдэлд амархан өртөх болон хурдан тархахад хүргэдэг. Энэ нь тухайн нутаг дэвсгэр элэгдэл, эвдрэлд өртөхөд голлох нөлөө үзүүлэх хүчин зүйл болно. Бороо ороход борооны ус 20-25 см гүн хүртэл нэвчих ба нэвчилт ихтэй газрууддаа 25 см-ээс ч илүү гүнд нэвчдэг. Энэхүү борооны дараах газрын гүнд нэвчсэн чийг нь тухайн нутаг дэвсгэрийн ургамлан бүрхэвчийн ургах нөхцөлийг хангахад чухал байдаг.

Нөлөөллийн шинж чанар, эх үүсвэр, хэмжээ, эрчим: Уулын малталт, олборлолтын ажлын талбайг бэлтгэх, зам шинээр гаргах зэрэг хөрсний өнгөн хуулалт хийх, газар шорооны ажлыг эхлүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор хөрс эвдэрч элэгдэлд орно. Уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизмын хөдөлгөөн, түрэлтээр орчны хөрсний үе давхаргууд гэмтэж, бороо хур ихтэй үед хөрсөн дээр хонхор үүсэж хөрс эвдрэх магадлалтай.

Олборлолтын үеийн хөрсний эвдрэлээс шалтгаалан шороон шуурга болох нь олшрох, тоосжилт нэмэгдэх, цөлжилтийг эрчимжүүлэх шалтгаан болж болзошгүй.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Уурхайн үйл ажиллагаа тухайлбал тэсэлгээ, нүүрс тээвэр зэргээс болоод уурхай орчмын газар болон машин замын ойролцоо газруудад хөрсний элэгдэл үүсэж, ургамлын нөмрөгийн зүйлийн бүрдэл буурах, амьтад дайжих зэрэг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

Мөн хөрсөнд шатах тослох материалын асгаралтаас үүдээд хөрс өөрийгөө цэвэршүүлэх, сэргээх чадвар алдагдах эрсдэлтэй.

Үргэлжлэх хугацаа: Хөрсний элэгдэл эвдрэл нь удаан хугацаагаар үргэлжилнэ. Хөрсний өөрийгөө нөхөн төлжүүлэх чадвар харьцангуй удаан байдаг.

4.3 Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нарийн сухайтын нүүрсний ордын “Монголын Алт” ХХК-ийн өнөөгийн ашиглаж буй ил уурхайн ар талаар буюу Нарийн сухайтын гол хагарлын дагуу баруунаас зүүн тийш чиглэсэн зурвас талбайд 2011 оны 07-р сарын 20-ноос 2011 оны 10-р сарын 05 хүртэлх хугацаанд газрын доорх усны эрэл хайгуулын ажлыг “Мангүүд” ХХК, “Монголын Алт” ХХК хамтран явуулж, “Монголын Алт” ХХК-ийн ашиглалтын лиценз бүхий талбайн баруун хойд захын цэгээс баруун тийш 1.3-3.8 км зайд газрын доорх усны тодорхой хэмжээний хуримтлал бүхий харьцангуй өндөр усжилттай дээд дөрөвдөгч-орчин үеийн настай сэвсгэр хурдасны болон дээд пермийн настай тунамал хурдасны уст давхаргыг илрүүлж нөөц бодсон байна.

Усны эх үүсвэр болох худгийн ойр орчимд гүний усыг бохирдуулах үйл ажиллагаа явуулах, урсгалын эхэнд ус бохирдуулах үйл ажиллагаа явуулах (машин угаах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях), шатах тослох материал хөрсөнд асгарах зэрэг нь хөрсний сул ус болон хур тунадсаар дамжиж ундны ус цаашлаад гүний усыг бохирдуулна.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Гүний худаг болон гадаргын усаар ундаалдаг хүн, мал амьтан, ургамал. Химийн хорт бодисууд усан сангийн ёроолд тунах үед эсвэл давхаргад нэвчих үед чулуулгийн хэсгүүдээр адсорбилогдох, исэлдэн ангижрах, тунадасжих гэх мэт процесс явагддаг тул ус өөрөө бүрэн цэвэршиж чаддаггүй. Гүний усанд химийн хорт бодисууд нэвчимтгий чанартай хөрсөнд 10 км ба түүнээс цааш тархаж болно.

Үргэлжлэх хугацаа: Хөрсөнд нэвчсэн хорт бодис нь гүний усанд уусаж удаан хугацаагаар хадгалагдана.

4.4 АМЬТАН, УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хөрс хуулалт болон тэсэлгээ, нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд орж ургамлын нөмрөг, тэжээллэг ашигт ургамлын зүйл буурах аажмаар алга болох эрсдэлтэй. Нүүрс тээвэр болон тэсэлгээний үед их хэмжээгээр тоосонцор агаарт дэгдэх үед нарны цацрагийн шууд тусгалыг хаах түүний нөлөөгөөр ургамлын ургалт багасаж анхдагч бүтээгдэхүүний бүтээмж буурах магадлалтай. Буурсан тохиолдолд идэш тэжээлийн гинжин хэлхээнд өөрчлөлт орох, амьтад идэш тэжээлээ даган нүүдэллэх тухайн нутгаас дайжих, хэрвээ идэш тэжээлээр дамжин хүнд металл болон химийн хорт нэгдлүүд амьтны биед орсон тохиолдолд тэдгээрийн гений санд өөрчлөлт орох гэх мэт эрсдэл гарч болзошгүй юм.

БҮЛЭГ 5. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу 2024 онд төлөвлөгөөт ажлуудыг авч хэрэгжүүлэн нөлөөллийг бага түвшинд байлгах, монгол улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон тусгаж боловсруулсан ба тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхэд оршино.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Байгаль орчны хяналтыг сайжруулах, сөрөг нөлөөллийг цаг алдалгүй илрүүлж, арилгах арга хэмжээг богино хугацаанд зохион байгуулах;
- Байгаль орчны чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, өргөжүүлэх;
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулах
- Мод үржүүлгийн талбайн ашиглалтыг сайжруулах төлөвлөгөөг гаргаж тарьц суулгацыг нөөцийг бүрдүүлэн, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарьж төрийн захиргааны төв байгууллагатай уялдаа холбоотой хамтран ажиллах
- Биологийн олон янз байдлыг хамгаалах дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргах

БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 АГААР ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛУУД

Зорилго: Уурхайн ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, орчны агаар дахь хими физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад оршино.

Хүснэгт 11. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл , түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Уурхайн тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах үүднээс бүх машин механизм, техникүүдийг тогтмол үзлэгт хамруулж, засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайн дотоод зам тээврийн талбай	Тайлан	-	3	Үйл ажиллагааны зардлаас	I-III Улирал бүр	MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ" MNS 4585:2016 Хүрээлэн буй орчны агаарын чанар
2		Зам талбайн тэмдэг тэмдэглэлээ нэмэгдүүлэх, Гайхам тээврийн хэрэгслийн хурдны хяналтын систем ашиглаж сар бүр хяналт тавьж, улирал бүр тайлан гаргах		Тайлан	100,000	30	3,000,000	Улирал бүр	
3		Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх, бүртгэл хөтлөх, тайлан гаргах	Уурхайн хэмжээнд	М ³	Шүүрлийн усны нэгж үнэ	3	Сар бүр тоолуурын заалтаар баталгаажуулан төлбөр төлөх	Улирал бүр	
4		Нүүрс тээврийн зам, бүтээлгийн талбайн хэсгийн тоосжилтыг	Ажлын тайлан	км	Үйл ажиллагааны зардлаас		Улирал бүр		

		бууруулах зорилгоор, тоос дарагч бодис ашиглах					
5	Төслийн үйл Ажиллагаанаас агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх	Хүлэмжийн хий ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, тооцоолох, ажилчдад сургалт явуулах	Уурхайн хэмжээнд	Тайлан	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр	MNS ISO 14064.1.2015
6		Шатах тослох материалын хадгалалтыг сайжруулах	Уурхайн хэмжээнд	Тайлан	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр	
7	Тэсэлгээний үйл ажиллагаанд хяналт тавих, бүртгэл, хөтлөх, тайлан гаргах		Уурхай болон уурхайн ажилчдын байр ойр орчим	Тэсэлгээний тоо	Үйл ажиллагааны зардалд багтсан	Улирал бүр	Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
8	Уурын зуухны үйл ажиллагаанд хяналт тавих, бүртгэл мэдээлэл хөтлөх,		Уурхайн орчимд	Сар бүрийн бүртгэл, мэдээлэл	Үйл ажиллагааны зардлаас	Сард нэг удаа	Дотоод дүрэм журам мөрдүүлэх
9	Баяжуулах үйлдвэрээс үүсэж буй тоосжилтыг бууруулахад ашиглах тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх		Бутлуур	Үйл ажиллагааны явцад	Үйл ажиллагааны зардлаас	I-III улирал	MNS 4585:2016 MNS 6063:2010
	НИЙТ				3,000,000		

6.2 ХӨРСӨН БҮРХЭВЧИД УЧРУУЛЖ БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Хөрсөнд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх, тайлан гаргах	Уурхайн хэмжээнд	га	Үйл ажиллагааны зардлаас			Улирал бүр	Уурхайн байгаль орчныг хамгаалах журам
2		Үржил шимт хөрсийг хуулж хэлбэржүүлэх, хянах, бүртгэх, тайлан гаргах	Уурхайн ахилтын талбай	га				Улирал бүр	MNS 5916:2008
3		Газар хөндөх зөвшөөрөл, ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой сургалт хийх, тайлан гаргах	Үйл ажиллагааны хүрээнд	-	Үйл ажиллагааны зардлаас			II улиралд	MNS 5917:2008
4	Уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизмын хөдөлгөөн, түрэлтээр орчны хөрсний үе давхаргууд гэмтэж, бороо хур ихтэй үед хөрсөн дээр хонхор үүсэж хөрс эвдрэх магадлалтай.	Тогтсон маршрутын дагуу хөдөлгөөнд оролцох	Уурхайн хэмжээнд	км	Үйл ажиллагааны зардлаас			Улирал бүр	Уурхайн замын хөдөлгөөний журам
5		Тосолгоо үйлчилгээг зориулалтын талбайд хийж буйд хяналт тавих	Үйлчилгээний талбайд	га					
6	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Хөрсний бохирдол, түүнийг арилгах талаар нийт ажилчдад сургалт явуулах	Уурхайн хэмжээнд	Жил	100,000	1	1,000,000	II, III улиралд	Дотоод төлөвлөгөө батлагдсан
7		Хөрс саармагжуулах талбай нэмж хийх	Засвар үйлчилгээний төвд	M ²	-	510	7,000,000	2-р улиралд	Дотоод төлөвлөгөө батлагдсан
Нийт								8,000,000	

6.3 УСАН ОРЧИНД ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛУУД

Зорилго: Уурхайн ажилчдын амьдрах орчинд ямар нэгэн бохирдолгүй усыг унд ахуйд хэрэглэх, уурхайн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулахад оршино.

Хүснэгт 13. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Усны эх үүсвэр болох худгийн ойр орчимд гүний усыг бохирдуулах үйл ажиллагаа явуулах, урсгалын эхэнд ус бохирдуулах үйл ажиллагаа явуулах (машин угаах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях), шатах тослох материал хөрсөнд асгарах зэрэг нь хөрсний сул ус болон хур тунадсаар дамжиж ундны ус цаашлаад гүний усыг бохирдуулна	Уурхайн үйл ажиллагаатай холбоотой усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	Уурхайн хэмжээнд	-	500,000	4	2,000,000	Улирал бүр	Усны тухай хууль
2.		Уурхайн худгийн тоолууруудын заалтыг авч акт үйлдүүлэх	Усны эх үүсвэр	ш	Усны төлбөрт төлсөн мөнгөн дүн			Сар бүр	Усны тухай хууль
3.		Усны нөөцийн савны ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн хэмжээнд	ш	1,500,000	4	6,000,000	Улирал бүр	Ундны усны эрүүл ахуй
4.		Булаг шанд, худаг усны орчинд цэвэрлэгээ хийх, засаж сайжруулах	Уурхайн эргэн тойрны булаг	ш	1,000,000	2	2,000,000	5 сар болон 9 сард	Усны тухай хууль
5.		Сумын иргэдтэй хамтарсан мониторинг хийх	Уурхайн хэмжээнд	төг	1,000,000	4	4,000,000	Улирал бүр	Усны тухай хууль
6.		Усны зүй зохистой хэрэглээ, усны менежментийн ойлголтын талаар нийт ажилчдад сургалт орох	Нийт ажилчдын дунд	төг	-	4	-	Улирал бүр	Усны тухай хууль
7.		НБҮ-ийн усны төлбөрийг ус ашиглах гэрээнд 327 дугаар тогтоолын дагуу тооцуулах	Уурхайн хэмжээнд	төг	Үйл ажиллагааны зардлаас			Сар бүр	Усны тухай хууль
8.		Уурхайн усны хэрэглээнд хяналт тавьж төлбөрийг тоолуурын заалтаар төлөх, III улиралд нэгдсэн тайлан гаргах	Уурхайн хэмжээнд	төг				Улирал бүр	Усны тухай хууль
9.		Дэлхийн усны өдрөөр уурхайн ажилчдын дунд тэмдэглэн өнгөрүүлэх	Уурхайн хэмжээнд	ш	3,000,000	1	3,000,000	1-р улиралд	Усны тухай хууль
10.		Ус ашиглалтын план зураг гаргах	Уурхайн хэмжээнд	ш	500,000	1	500,000	1-р улиралд	Усны менежментийн төлөвлөгөө
11.		Усны баланс гаргах, бүртгэх	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардлаас			Улирал бүр	Усны менежментийн төлөвлөгөө
12.		Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, малчдад зөвлөмж өгөх, малын онгоц хийж малчны гар худгуудад байрлуулах	Гурвантэс сум	ш	-	3	Үйл ажиллагааны зардлаас	3 улиралд	Усны менежментийн төлөвлөгөө
13.		Уурхайн мониторингийн цооногт усны автомат түвшин хэмжигч суурилуулах	Хяналт цэгүүдэд	ш	Үйл ажиллагааны зардлаас			2 улиралд	Усны менежментийн төлөвлөгөө

14.	Ус ашиглах дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, бусдад худалдан борлуулах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх.	Уурхайн хэмжээнд	Жил	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр	Усны тухай хууль
15.	Ажилчдын хотхоны цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарч байгаа саарал усыг зам усалгаа, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Уурхайн хэмжээнд	Жил	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр	Усны менежментийн төлөвлөгөө
НИЙТ ЗАРДАЛ		17,500,000				

6.4 АМЬТНЫ АЙМАГТ УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй бүс нутагт тархсан зэрлэг ан амьтанд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 14. Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн олборлолт, барилга байгууламж өргөжин тэлж байгаагаас зам, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний гэрлийн нөлөөгөөр байршиж буй газраасаа ан амьтад үргэх дайжих, амьдрах орчны хомсдолд орох	Уурхай орчмын 20 км радиуст амьтны судалгаа хийх	Уурхайн орчимд	ш	1,000,000	4	4,000,000	Улирал бүр	Амьтны судалгаа хийх аргачлал
2		Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбай дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих талаар жолооч нарт сургалт явуулах	Үндсэн болон гэрээт компанийн ажилчид	Хамрагдсан ажилчдын тоо	1,000,000	2	2,000,000	Улирал бүр	Амьтны тухай хууль
3		Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах	Гурван тэс суманд	ш	2,000,000	2	4,000,000	Жилд 2 удаа	Амьтны тухай хууль
4		"Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	Сурагч болон ажилчдын дунд	ш	5,000,000	1	5,000,000	3-р улиралд	"Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх
5		Уурхайн үйл ажиллагааны талбай, дэд бүтэц, цахилгааны шугам дагуух үхсэн амьтны сэг зэмийг зайлуулах, булж устгах, хорогдсон амьтадын бүртгэл хөтлөх	Уурхайн талбай	Эндсэн амьтдын тоо	2,000,000	2	2,000,000	Улирал бүр	Амьтны тухай хууль
Нийт							17,000,000		

6.5 УРГАМЛЫН АЙМАГТ УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй бүс нутагт тархсан байгалийн ховор, нэн ховор ургамлын аймагт үзүүлж буй сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, бууруулахад оршино.

Хүснэгт 15. Ургамлын аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ургамлын нөмрөг, ховор ургамлууд нөлөөлөлд өртөж доройтох, устгах, дарагдах,	Ховор, нэн ховор ургамалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд ажиглалт судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх	Уурхайн орчимд	Судалгааны тоо	2,00,000	2	4,000,000	II, III улиралд	Судалгаа хийх аргачлал Байгаль хамгаалах тухай хууль
2		Бүс нутагт ургадаг ховор ургамлын гэрэл зургийн үзэсгэлэнг танин мэдүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Уурхайн орчимд	Судалгааны тоо	6,000,000	1	6,000,000	II улирал – Цөлжилттэй тэмцэх өдрөөр	
3		Нутгийн унаган ургамлыг тарьж турших	Уурхайн орчимд	Төрөл зүйлийн тоо	1,000,000	2	2,000,000	II, III улиралд	
4		Газар хөндөх бүсэд өртөж буй ховор ургамлыг хамгаалах, шилүүлэн суулгах арга хэмжээг зохион байгуулах	Уурхайн орчимд	Шилжүүлсэн ургамлын тоо	-	-	-	Улирал бүр	
Нийт							12,000,000		

БҮЛЭГ 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Нарийн сухайтын уурхайн нь одоогийн байдлаар орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цаашид нөхөн сэргээлт болон шимт хөрсний овоолгын хадгалалтыг сайжруулахад ашиглах говийн унаган болон дасан зохицон ургах чадвартай ургамлуудыг үрээр болон суулгацаар тарьж үржүүлэх, турших тал дээр түлхүү анхааран ажиллаж байна. 2023 онд энэхүү ажлыг илүү боловсронгуй, үр дүнтэй болгох үүднээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Үүнд :

Хүснэгт 16. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт	Хүлэмж болон ил талбайд үрээр тарилт хийх	кг	2	-	2,500,000	2 улиралд	Ургамал хамгааллын тухай хууль Мод үржүүлгийн талбайн бүтэц зохион байгуулалт Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, MNS 5915:2008 MNS 5916:2008 MNS 5917:2008 2023 оны БОМТ-ний дүгнэлт
2		Хоолны хог хаягдлаар компост бордоо хийж нөхөн сэргээлтийн талбайд ашиглах	тн	0,5	-	3,000,000	Улирал бүр	
4	Техникийн нөхөн сэргээлт	Гурвантэс сумруу гарсан олон салаа замыг хааж, нөхөн сэргээлт хийх	га	3	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр		
5	Шимт хөрсний үржил шим нэмэгдүүлэх	Шимт хөрсний 4 болон 5 дугаар овоолгуудад үржил шимийг нэмэгдүүлэх хадгалалтыг сайжруулах зорилгоор олон наст тарьж хашиж хамгаалах	га	2	-	4,500,000	2 улиралд	
6	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Бүх нийтээр мод тарих өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, мод тарих	ш	4000	3500	14,000,000	2 улиралд	
7		Заг тарих талбайг сонгох, дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргах	Га	10	-	5,000,000	II,III улирал	
Нийт						29,000,000		

БҮЛЭГ 8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримтлан дүйцүүлэн хамгаалах ажилд дунд болон урт хугацааны төлөвлөө гарган ажлыг шат дараатайгаар гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 17. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хиймэл дагуул ашиглах тохиромжтой нутгийн судалгаа хийх, судалгааны дагуу ажиглалт хийж, сансрын мэдээлэл дамжуулах хүзүүвчийг хар сүүлт зээрд зүүх	Амьтан барих хүзүүвчлэх зөвшөөрөл авах	Өмнөговь аймгийн Гурвантэс сум Хөхөлзөхийн говь	3 бодгаль	-	24,364,560	I-III улирал	"Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээний дүрэм журмыг дагаж мөрдөн ажиллана.
2		Хар сүүлт барих хүзүүвчлэх						
3		Хүзүүвчнүүдийг программчлах, хиймэл идэвхжүүлж мэдээлэл цуглуулах горимд шилжүүлэх						
4		Орон нутгийн иргэдтэй хамтран судалгаа хийх						
5		Улирлын шилжилт хөдөлгөөний тайлан гаргах						
6		Нэгдсэн тайлан гаргах						
7	Мазаалайг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэх	Мазаалай дамжин өнгөрч буй Гурвантэс сумын нутаг дэвсгэрт тэжээлийн сав байрлуулах	Өмнөговь аймгийн Гурвантэс сум Тостын нуруу	2 ш	-	-	II, III улирал	
Нийт						24,367,560		

БҮЛЭГ 9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нарийн сухайтын уурхайн нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох Дов хэмээх газар Д.Мөнхсайхан мөн Хөх толгой гэх газар А.Амартүвшин, Суваргад өвөлждөг Ц.Уранмандах нар нь тус тус 1500 м.кв газруудыг өвөлжөө хаваржааны зориулалтаар тус тус 60 жилийн хугацаатайгаар эзэмшдэг байсныг Монгол улсын ашигт малтмалын болон газрын тухай хууль түүнтэй холбогдох журмуудыг үндэслэн эдгээр айлуудтай зөвшилцөн 2014 оны 2 дугаар сард байгуулсан нөхөн төлбөр олгох тухай № 018-0914, № 019-0914 тоот, мөн 2023 оны 08 сарын 28-ны өдрийн №882-1223 тоот гэрээнүүдийн дагуу тус айлуудад нөхөн олговрыг олгож дууссан.

Хүснэгт 18. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор өгөх төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нөлөөлөлд өртөх иргэд	Өрхийн хөгжил, амьжиргааны түвшний судалгаа хийх	Нөхөн олговрын гэрээтэй өрхүүд	3 өрх	3,000,000	3,000,000	II-III улиралд	Монгол улсын хууль, журам стандарт
2		Нөлөөлөлд өртсөн айл өрхийн гишүүдийг тогтвортой ажлын байраар хангах	Нөхөн олговрын гэрээтэй өрхүүд	2 өрх	Үйл ажиллагааны зардлаас	II-III улиралд		
Нийт						3,000,000		

БҮЛЭГ 10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаа явагдах хугацаанд уурхайн болон гэрээт байгууллагын ажилчдад үнэт олдвор, уламжлалт ёс заншлыг таниулж мэдлэг олгох, тэдгээр түүх соёлын өвийг хамгаалахад оршино.

Хүснэгт 19. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нийт ажилчдад “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ыг хэрэгжүүлэх тухай сургалтыг явуулах		Уурхайн нийт ажилчдад	1	Үйл ажиллагааны зардлаас	I,II улирал	“Санамсаргүй олдворын үед ажиллах журам”, ХАБЭАБО-ны хэсгийн сургалт орох хуваарь
2	Түүхэн дурсгалт кино үзүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулах, урамшуулах		ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд	1	3,000,000	I улирал	Соёлын өвийг хамгаалах тухай хууль, БОННУ боловсруулах журам
3	Монголын түүхийг танин мэдүүлэх зорилгоор ананос, постер сургуулийн коридорудад байрлуулах		ЕБС	10	2,000,000	II улирал	Соёлын өвийг хамгаалах тухай хууль, БОННУ боловсруулах журам
Нийт					5,000,000		

БҮЛЭГ 11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагааны явцад химийн бодисоос үүдсэн ямар нэгэн сөрөг нөлөө үүсэж байгаль орчинд сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад оршино. Компанийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа “Хортой ба аюултай бодисын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллана.

Хүснэгт 20. Осол эрсдэлээс үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Цэвэр усан хангамж, бохир усны шугам, түүний хамгаалалт, хаалтыг шалгаж бэлэн байлгах	Уурхайн бүх барилга байгууламж	4	Үйл ажиллагааны зардлаас		Улирал бүр	Батлагдсан үзлэгийн хуваарь, үзлэгийн бүртгэл
2	Химийн хортой болон аюултай бодисын тухай хуулийн 13.6-д заасан сургалтыг химийн бодистой хамааралтай ажиллах ажилтнуудад хийх	Уурхайн хэмжээнд	4	100,000	400,000	Улирал бүр	Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль, Уурхайн батлагдсан сургалтын хуваарь
3	Химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байршуулан, хяналт тавих		Үйл ажиллагааны зардлаас		Улирал бүр	Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам	
4	Химийн бодисын бүртгэлийг сар бүр хийж, түр хадгалах цэгт хяналт тавих		Үйл ажиллагааны зардлаас		Тухай бүрд		
5	Уурхайн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг тогтвортой байдлыг хангаж ажиллах		4	Үйл ажиллагааны зардлаас		3-4-р улиралд	MNS BS 8525-1:2015
6	Хаягдал тосны агуулах дүүрэхэд гэрээт компанид хүлээлгэн өгөх		Гэрээний дагуу		Сар бүр	"Монфити ойл" ХХК-тай хамтран ажиллах гэрээ	
7	Хаягдал тосны агуулахыг нарны тусгалаас хамгаалах зорилгоор дээвэр хийх		1	2,000,000	10,000,000	II улирал	Аюултай бодис хадгалалт
8	Тосны агуулахын дээврийг засварлах, шинэчлэх		1	Үйл ажиллагааны зардлаас		II улирал	
Нийт зардал					10,400,000.00		

БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн шингэн болон хуурай хог хаягдлын нөлөөгөөр байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх, ямар нэгэн байдлаар бохирдсон тохиолдолд тухайн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад оршино.

Хүснэгт 21. Хог хаягдлаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Ахуйн хог хаягдал гаргасны төлбөрийн гэрээг хийж төлбөрийг төлөх	Уурхайн хэмжээнд	төг	500	-	-	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
2		Уурхайн орчны хог хаягдлын цэвэрлэгээ хийх хуваарь гаргах батлуулж цэвэрлэгээг хийх	Уурхайн орчимд	ш	Үйл ажиллагааны зардлаас			Хуваарьт өдөр бүр	
3		Хог хаягдлыг "Шугшаа Уул" ОНӨААТ ҮГ-аар устгуулах	Гэрээний дагуу	м3	55000	-	-	Сар	"Шугшаа Уул" ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээ
4		Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг эх үүсвэрээс ангилан ялгалт хийх буйд хяналт тавьж бүртгэл хөтлөх, дахин ашиглах боловсруулах талаар сургалт орж шинэлэг санааг гаргаж хэрэгжүүлэх, хогийн савнууд, хаягийг шинэчлэх	Уурхайн орчимд	м3	-	1	5,000,000	Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль
5		Хуванцар савыг пресслэгч машинаар стандартын дагуу пресслэж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Бүлэг ордын хэмжээнд	м3	-	1	7,000,000	Улирал бүр	2023 БОМТ дүгнэлт
6		Үйлдвэрийн	Химийн бодисын сав баглаа боодлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Гэрээний дагуу	ш	Үйл ажиллагааны зардлаас			Улирал бүр

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Нарийн сухайтын нүүрсний
уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

7		Эмнэлгийн хог хаягдлыг Гурвантэс сумын эмнэлэгтэй гэрээ хийж устгуулах	Гэрээний дагуу	төг	576,000	1	576,000	Улирал бүр	тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх журам
8	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах устгах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх	Уурхайн орчимд	ш	Үйл ажиллагааны зардлаас			Улирал бүр	
9		Аюултай хог хаягдлыг хуримтлуулж эхэлсэн бас дууссан хугацааны бүртгэх	Хуулийн хүрээнд	-				Улирал бүр	
Нийт					12,576,000				

БҮЛЭГ 13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Зорилго: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хяналтын цэгүүдэд, хуваарийн дагуу хийж уурхайн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг хянах, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх мөн стандартын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор хяналт шинжилгээний дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 22. 2024 оны хэмжилт хийх давтамж, байршил, зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Нарийн сухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудтай хамтран мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх	Уурхайн хяналтын бүх цэгт	III улирал	1	12,000,000	12,000,000	Тухайн жилийн БОМТ
Агаарын хяналт шинжилгээ							
2	Тоосжилтын хэмжээ (PM2.5 PM 10) Агаар бохирдуулах эх үүсвэрийг хянах (NO2, SO2, CO, CO2)	Уурхайн хяналтын цэгүүдэд	Улирал бүр	4	200,000.00	800,000	“Агаарын чанар”, MNS 4585:2016 “Агаар орчны чанарын үзүүлэлт”
Усны хяналт шинжилгээ							
3	Усны мониторинг хийх	Мониторингийн бүх цооногуудад	Улирал бүр	6	500,000	3,000,000	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
4	Хими болон физикийн үзүүлэлт Усны химийн найрлага, хүнд металлын агууламж, бактериологи, органик бохирдол	Хотхон, дунд хотхон, зоогийн газар, бохир уснаас мөн шүүрлийн ус, их ус	Улирал бүр	4	1,000,000	4,000,000	MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөвөрлөх
5	Усны химийн найрлага, хүнд металлын агууламж, бактериологи	Сухайн булаг, Ногоон чулууны булаг	I,III-р улиралд	2	200,000	400,000	MNS ISO 5667-10:2001 Усны чанар-Дээж авах
6	Усны түвшний хэмжилт	Мониторингийн цооногуудад	Улирал бүр	4	200,000	800,000	

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Нарийн сухайтын нүүрсний
уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		Малчдын гар худагт					
		Нөлөөллийн бүсийн цооногууд					
Хөрсний хяналт шинжилгээ							
7	Хөрсний ерөнхий үзүүлэлтүүд болон хүнд металлууд	НБҮ-ийн химийн бодисын агуулах орчмоос	Улирал бүр	4	200,000	800,000	MNS 3298 : 1991.; MNS 5850 - 2008
		Засварын талбай					
		Хогийн цэг					
		Шатахууны агуулах					
8	Агрохимийн шинжилгээ	Шимт хөрсний овоолго тус бүрээс	8 сард	1	250,000	1,500,000	
9	Баяжуулах үйлдвэрийн хаягдал хүнд металлын шинжилгээ хийлгэх	НБҮ хаягдал	Улирал бүр	4	100,000	400,000	Дээжийг итгэмжлэгдсэн лаборатори шинжүүлж хянах
10	Хөрсний бактериологийн шинжилгээ	Хогийг цэг, цэвэрлэх байгууламж	4, 8-р сард	2	200,000	800,000	Дээжийг итгэмжлэгдсэн лаборатори шинжүүлж хянах
Ургамлын хяналт шинжилгээ							
11	Ургамлын гарц, ургац, төрөл зүйл, бүлгэмдэл, ховор ургамал зэргийг судлан мониторинг хийх	Ургамлын хяналтын цэгүүдэд	7 сард	1	500,000	500,000	Зүйлийг тоолж бүртгэх бүрхэц арвийг нүдэн баримжааны аргаар
12	Үрийн соёлолт хяналт мониторинг хийх /заг, хайлаас, гүйлс/	Уурхайн орчимд	5, 9 сард	1	500,000	500,000	Үр түүх стандарт
Амьтны хяналт шинжилгээ							
13	Амьтан /анхан шатны мэдээлэл цуглуулах/ амьтны төрөл зүйл бүртгэж авна.	Амьтны хяналтын цэгүүдэд	Улирал бүр	4	200,000	800,000	“Монгол орны хөхтөн амьтдын экологи биологийн нэгдсэн аргазүй”, “Барих-Тэмдэглэх-Дахин тэмдэглэх аргазүй”,
Нийт						26,300,000	

БҮЛЭГ 14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаа явуулах хугацаанд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, сурталчилгаа, мөрдөгдөх журам, төлөвлөгөөг цаг алдалгүй хийх тухайн ажлыг зөв зүйтэй зохион байгуулахад оршино.

Хүснэгт 23. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн үйл ажиллагаа, сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн тухай орон нутгийн иргэдэд танилцуулах, өдөрлөг зохион байгуулах	Уурхайд	1	3,000,000	Улирал бүр	БО- Хуулийн хүрээнд
2	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг орон нутгийн иргэдэд танилцуулан уулзалт зохион байгуулах	Уурхайн нийт ажилчдад	1	2,000,000	Улирал бүр	Дотоод сургалтын төлөвлөгөө болон гадаад сургалтын хуваарьт
4	Хамтран ажиллах гэрээний хүрээнд хариуцсан Гурвантэс сумаас-Овоот холбосон 7,2 зам талбайн зам арчилгааны ажлыг гүйцэтгэх, төлөвлөгөө батлах	Дотоод	4	2,000,000	3-р улиралд	Хамтран ажиллах гэрээний хэрэгжилт
5	2024 он зохион байгуулагдах байгаль орчны чиглэлийн бүх семинар, хурал зөвлөгөөнд оролцох	Орон нутаг	-	Үйл ажиллагааны зардлаас	-	Дотоод баглагдсан төлөвлөгөөний хүрээнд
6	Багийн иргэдэд цаг агаарын мэдээ мэдээллийг мессежээр хүргүүлэх, улирлаар тайлан гаргах	Бага – Овоо багийн иргэд	I-III улирал	Үйл ажиллагааны зардал	7 хоног бүрийн мэдээллийг хүргүүлнэ	Малчдыг цаг уурын мэдээллээр хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх
7	Гурвантэс суманд хувиараа мод үржүүлэг болон хүлэмжийн аж ахуй эрхэлдэг иргэдийн уулзалт зохион байгуулах, туршлага солилцох	Уурхайд	2	4,000,000	I, III улиралд	Орон нутгийн иргэдтэй туршлага солилцох, хамтран ажиллах
Нийт				11,000,000		

БҮЛЭГ 15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа орон нутгийн иргэд болон төрийн байгууллагыг үнэн зөв бодит мэдээллээр хангахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Үүнд:

- Орон нутгийн иргэдтэй уулзаж хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээллийг хүргэж байх
- Төрийн байгууллагуудад журмын дагуу тайлангийн биелэлт, гүйцэтгэлийг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх (Тухайн цаг хугацаанд)
- Бусад үед шаардлагатай мэдээ, судалгааг гаргаж төрийн байгууллагуудад хүргүүлэх (Тухайн цаг хугацаанд)

Хүснэгт 24. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Гурвантэс сумын иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн	Иргэдийн хурал	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт	10-р сард	1,000,000	Байгаль орчны мэргэжилтэн	Бага овоо багийн төв
2	Өмнөговь аймгийн Гурвантэс сумын ИНХ	Тайлан		11-р сард	1,000,000		Уурхай дээр
3	Сөрөг нөлөөлөл бууруулах чиглэлээр хийгдэж буй ажлыг улирал бүр тайлагнах	Сум болон багийн иргэдэд		Улирал бүр	4,000,000		Уурхай дээр
Нийт					6,000,000		

БҮЛЭГ 16. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО

Тухайн жил байгаль орчныг хамгаалах ажилд 158.9 сая.төг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 26.3 сая.төг зарцуулахаар төсөвлөв. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийтдээ 185.0 сая.төг зарцуулна.

Хүснэгт 25. Төлөвлөгөөний урьдчилсан зардал

№	Хийгдэх ажлууд	Зардал, сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	57.5
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	29.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	24.4
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговрын зардал	3.0
5	Түүх соёлын өвийг хамгаалах зардал	5.0
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	10.4
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	12.6
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26.3
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	11.0
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	6.0
	Нийт	185.0